



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 29 өдөр

Дугаар А/62

Шивээговь сум

Тооллого зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Статистикийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.в, 20 дугаар зүйлийн 20.2, аймгийн Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн А/159 дугаар "Комисс томилох тухай" захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын 2023 оны хагас жилийн мал тооллогыг 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдрөөс 06 дугаар сарын 06-ны өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулсугай.

2. Тооллогын ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Ч.Сугармаа

(Засаг даргын орлогч дарга)

Гишүүд:

С.Отгонбаатар

(1 дүгээр багийн Засаг дарга)

Д.Маналмаа

(2 дугаар багийн Засаг дарга)

П.Ганжаргал

(Мал аж ахуйн үйлдвэрлэлийн төлөвлөлт, менежмент, малын үржил бүртгэлийн асуудал хариуцсан мэргэжилтэн)

Д.Мөнхзаяа

(Бэлчээр, газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга:

Д.Өлзийсүрэн

(Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн)

3. Тооллого явуулахтай холбогдуулан түүврээр сонгогдсон өрхийг тооллогод бүрэн хамруулж, тооллогын ажлыг удирдлага, арга зүйгээр хангаж, товлосон хугацаанд зохих журмын дагуу зохион байгуулж, үр дүнг танилцуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Ч.Сугармаа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



П. ГАНЧИМЭГ